Бараа материал	427,604.6	2.6%	149,574.4	5.3%	(278,030.2)	-65.0%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,393,077.0	93.1%	2,142,505.8	76.4%	(13,250,571.2)	-86.1%
Үндсэн хөрөнгө	20,267,446.0	122.5%	5,591,471.2	199.4%	(14,675,974.8)	-72.4%
Хуримтлагдсан элэгдэл	(4,874,368.9)	-29.5%	(3,448,965.4)	-123.0%	1,425,403.6	-29.2%
Нийт хөрөнгө	16,538,999.3	100.0%	2,804,702.6	100.0%	(13,734,296.7)	-83.0%
Өр төлбөр	14,237.7	0.1%	6,575.2	0.2%	(7,662.4)	-53.8%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	16,524,761.6	99.9%	2,798,127.4	99.8%	(13,726,634.2)	-83.1%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,538,999.3	100.0%	2,804,702.6	100.0%	(13,734,296.7)	-83.0%

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Эргэлтийн бус хөрөнгийн дүн өмнөх оноос 13,734,296.7 мянган төгрөгөөр буурсанд төсвийн шинэчлэлтэй холбоотойгоор эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, соёлын төвийн хөрөнгийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлэн бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 321,800.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 69,208.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө	252,592.5	321,800.7	69,208.2	100.0
Дүн	252,592.5	321,800.7	69,208.2	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 26,795.9 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд, Хоршоог хөгжүүлэх сангийн дансанд 47,903.7 мянга, орон нутгийн ерөнхий орлогын дансанд 196,984.4 мянган төгрөг байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 190,821.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 274,703.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	730.5	741.9	11.4	0.4
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	10.0	10.0	0.0
Татаас, санхүүжилтийн авлага	327,086.0	-	(327,086.0)	-
Байгууллагаас авах авлага	2,712.2	-	(2,712.2)	-
Зээлийн авлага	134,996.5	190,069.8	55,073.3	99.6
Дүн	465,525.1	190,821.7	(274,703.5)	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд авлага дансны үлдэгдэл өссөн шалтгаан нь өмнөх онд сумын Эрүүл мэндийн төв нь ЭМД-ын сангаас авах санхүүжилтийн авлага болох 327,086.0 мянган төгрөгийг хүлээн авч барагдуулж, хоршоо хөгжүүлэх сангаас 2022 онд 100,000.0 мянган төгрөгийн зээл олгож авлагаар тусгасантай холбоотой байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл /байгууллагаар/

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	717.9	717.9	-	0.4
Засаг даргын тамгын газар	383.8	34.0	(349.8)	0.0
Хоршоо хөгжүүлэх сан	134,996.5	190,069.8	55,073.3	99.6
Эмнэлэг	327,086.0	-	(327,086.0)	-
Сургууль	2,328.4	-	(2,328.4)	-
Цэцэрлэг	12.6	-	(12.6)	-
НИЙТ ДҮН	465,525.1	190,821.7	(274,703.5)	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 149,574.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 278,030.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	45,989.9	3,900.0	(42,089.9)	2.6
Эм боох материал	40,696.7	-	(40,696.7)	-
Бэлэн бүтээгдэхүүн	1,129.7	-	(1,129.7)	-
Бичиг хэргийн материал	9,491.4	4,154.8	(5,336.5)	2.8
Аж ахуйн материал	69,812.8	1,852.9	(67,959.9)	1.2
Түлш, шатах тослох материал	1,479.7	300.0	(1,179.7)	0.2
Барилгын засварын материал	6,832.0	4,392.0	(2,440.0)	2.9
Хүнсний материал	11,641.6	-	(11,641.6)	-
Бусад хангамжийн материал	240,530.8	123,974.7	(116,556.1)	82.9
Мал амьтад	-	11,000.0	11,000.0	7.4
Дүн	427,604.6	149,574.4	(278,030.2)	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 149,574.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 278,030.2 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төв 73,840.9 мянга, боловсролын салбар 228,459.3 мянга, Соёлын төвийн 12,861.0 мянга, нийт 315,161.2 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1,852.9	1,852.9	-	1.2
Засаг даргын тамгын газар	110,590.5	147,721.5	37,131.0	98.8
Орон нутгийн хөгжлийн сан	-	-	-	-
Хоршоо хөгжүүлэх сан	-	-	-	-
Эмнэлэг	73,840.9	-	(73,840.9)	-
Соёлын төв	12,861.0	-	(12,861.0)	-
Сургууль	128,809.3	-	(128,809.3)	-
Бага сургууль	16,980.2	-	(16,980.2)	-
Цэцэрлэг	68,966.1	-	(68,966.1)	-
Бага цэцэрлэг	13,703.6	-	(13,703.6)	-
НИЙТ ДҮН	427,604.6	149,574.4	(278,030.2)	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 5,591,471.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 14,675,974.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	20,086,883.8	5,559,493.2	(14,527,390.6)	99.4
Барилга байгууламж, орон сууц	17,793,093.5	4,736,867.2	(13,056,226.3)	84.7
Тээврийн хэрэгсэл	349,530.5	290,330.5	(59,200.0)	5.2
Машин тоног төхөөрөмж	871,211.0	256,267.0	(614,944.0)	4.6
Тавилга эд хогшил	377,193.9	116,916.6	(260,277.3)	2.1
Түүх соёлын дурсгалт зүйл	7,000.0	7,000.0	-	0.1
Дуусаагүй барилга, байгууламж	506,816.0	-	(506,816.0)	-
Номын фонд	60,337.0	-	(60,337.0)	-
Бусад үндсэн хөрөнгө	121,701.8	152,111.8	30,410.0	2.7
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	180,562.2	31,978.0	(148,584.2)	0.6
Программ хангамж	18,974.2	13,978.0	(4,996.2)	0.2
Бусад биет бус хөрөнгө	161,588.0	18,000.0	(143,588.0)	0.3
НИЙТ ДҮН	20,267,446.0	5,591,471.2	(14,675,974.8)	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,591,471.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 14,675,974.8 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төв 2,142,782.8 мянга, соёлын төвийн 3,876,369.2 мянга, Боловсрол шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар байгуулагдсантай холбоотойгоор боловсролын байгууллагуудын 8,799,957.0 мянга нийт 14,819,109.1 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлэн бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	18,919.0	38,919.0	20,000.0	0.7
Засаг даргын тамгын газар	5,429,417.9	5,552,552.2	123,134.3	99.3
Орон нутгийн хөгжлийн сан	-	-	-	-
Хоршоо хөгжүүлэх сан	-	-	-	-
Эмнэлэг	2,142,782.8	-	(2,142,782.8)	-
Соёлын төв	3,876,369.2	-	(3,876,369.2)	-
Сургууль	7,197,825.8	-	(7,197,825.8)	-
Бага сургууль	271,111.1	-	(271,111.1)	-
Цэцэрлэг	1,324,150.6	-	(1,324,150.6)	-
Бага цэцэрлэг	6,869.5	-	(6,869.5)	-
НИЙТ ДҮН	20,267,446.0	5,591,471.2	(14,675,974.8)	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд нэмэгдсэн 95,617.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн 12,341.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, 83,276.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл

/мянган төгрөгөөр/

Нэмэгдсэн	95,617.8	Хасагдсан	8,621,457.6
Худалдан авсан	12,341.0	Худалдсан	-
Хандиваар	-	Акталсан	13,693.7
Шилжүүлэн авсан	11,271.3	Шилжүүлсэн	8,607,763.9
Бусад	72,005.5	Бусад	-

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 6,575.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,662.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	14,237.7	6,575.2	(7,662.4)	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	1,097.1	5.1	(1,092.0)	0.1
Бараа, үйлчилгээний зардлын өглөг	13,134.3	6,570.1	(6,564.2)	99.9

Аудитын код: БНА-2023/6/НА-СТА-ТТЗ

Хуудас-16

Бууцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагад төлөх өглөг	-	-	-	-
Хувь хүмүүст төлөх өглөг	6.3	-	(6.3)	-
Дүн	14,237.7	6,575.2	(7,662.4)	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Хүснэгт 11. Өглөгийн дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	-	3,729.4	3,729.4	56.7
Засаг даргын Тамгын газар	3,422.5	2,845.9	(576.7)	43.3
Эмнэлэг	8,493.5	-	(8,493.5)	-
Сургууль	87.0	-	(87.0)	-
Бага сургууль	36.3	-	(36.3)	-
Цэцэрлэг	2,156.3	-	(2,156.3)	-
Бага цэцэрлэг	42.0	-	(42.0)	-
НИЙТ ДҮН	14,237.7	6,575.2	(7,662.4)	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,798,127.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,726,634.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,132,340.9	537,862.8	(1,594,478.1)	19.2
Өмч: - төрийн	2,132,340.9	537,862.8	(1,594,478.1)	19.2
Хуримтлагдсан үр дүн	11,367,537.4	1,840,901.5	(9,526,635.9)	65.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,024,883.3	419,363.1	(2,605,520.2)	15.0
Дүн	16,524,761.6	2,798,127.4	(13,726,634.2)	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,798,127.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,726,634.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 9,526,635.9 мянга, сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төвийн хөрөнгө улсын төсөвт шилжсэнтэй холбоотой 4,199,998.3 мянган төгрөгийн өөрчлөлттэй холбоотой байна.

3.5.11 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2021.12.16-ний өдрийн хуралдаанаар 5/08 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 307,563.4 мянга, хүү торгуулийн орлогыг 37,000.0 мянга, нийт 344,563.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 12. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	307,563.4	453,273.8	143,782.2	147.4
1.10. ЦХТАО /суутган-1/	129,000.0	179,330.6	50,330.6	139.0
1.1.ИОТХ	20,000.0	20,199.1	199.1	101.0
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	55,000.0	34,020.2	-20979.8	61.9
1.3. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,000.0	2,232.1	1,232.1	223.2
1.4. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	4,000.0	4,232.9	232.9	105.8
1.5.Бууны татвар	2,000.0	2,310.0	310.0	115.5
1.6.Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	4,654.8	2,654.8	232.7
1.7. Газрын төлбөр	5,000.0	3,427.3	(1,572.7)	68.5
1.8.Ан агнуурын нөөц ашигласны төлбөр	-	142,565.3	142,565.3	-
1.9. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	9,000.0	4,630.0	(4,370.0)	51.4
1.10. ТТАМАТөлбөр	500.0	1,133.3	633.3	226.7
1.11. Ус ашигласны төлбөр	-	1,928.2	1,928.2	-
1.12. Малын тоо толгойн албан татвар	80,063.4	52,610.0	(27,453.4)	65.7
2.Татварын бус орлого	37,000.0	29,426.0	7,120.0	79.5

Аудитын код: БНА-2023/6/НА-СТА-ТТЗ

Хуудас-17

2.1.Хүү торгуулийн орлого	37,000.0	29,426.0	7,120.0	79.5
Нийт дүн	344,563.4	482,699.8	150,902.2	140.1

Эх сурвалж: Бууцагаан сумын ИТХ-ын тогтоол

Сумын төсөвт төвлөрөх орлогыг 150,902.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн ба үүнд цалин, хөлс түүнтэй адилтгах орлогын татвар, ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзвэл түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого огт ороогүй, хадгаламжийн хүү, үл хөдлөх борлуулсны, буу, малын тоо, толгой, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдлын үйлчилгээний төлбөр гэсэн орлогын нэр төрлүүдээр төлөвлөгөө биелээгүй байна.

3.5.12 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,817,829.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,616,031.1 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,236,576.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 379,454.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.16-ний өдрийн 5/08 дугаар тогтоолоор нийт 1,957,391.8 мянган төгрөгийг анх баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2021.12.16-ны өдрийн 5/08 дугаар тогтоолоор анх 1,957,391.8 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2022.06.10-ний өдрийн 7/01 дугаар тогтоолоор 139,562.0 мянган төгрөгөө бууруулж 1,817,829.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Нийт зардлын 344,563.4 мянган төгрөгийг сумд төвлөрөх татварын болон татварын бус орлогоос, 824,592.3 мянган төгрөгийн аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс, 260,184.9 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 136,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 252,489.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 150,902.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, аймгаас авах санхүүгийн дэмжлэг 824,592.3 мянган төгрөгийг бүрэн авч, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас авах санхүүжилтийг 1,431.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжсэн байна.

Хүснэгт 14. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төвлөрүүлсэн
Засаг даргын Тамгын газар	444,937.2	437,754.7	7,182.5	98.4	7,182.5
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	88,870.2	87,729.1	1,141.1	98.7	1,141.1
Соёлын төв	48,362.2	47,507.6	854.6	98.2	854.6
Хоршоо хөгжүүлэх сан	235,188.0	105,581.5	129,606.5	44.9	129,606.5
Сургууль	380,354.0	380,036.7	317.3	99.9	317.3
Цэцэрлэг	61,464.8	59,974.0	1,490.8	97.6	1,490.8
Эрүүл мэндийн төв	81,298.4	80,169.9	1,128.5	98.6	1,128.5
Орон нутгийн хөгжлийн сан	435,062.0	379,454.4	55,607.6	87.2	55,607.6
Бага сургууль	30,422.8	28,363.6	2,059.2	93.2	2,059.2
Бага цэцэрлэг	11,870.0	9,459.7	2,410.3	79.7	2,410.3
Нийт дүн	1,817,829.6	1,616,031.1	201,798.5	88.9	201,798.5

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 91.6 хувьтай байгаа нь ЗДТГ-ын төсвийг 7,182.5 мянга, ИТХ-ын төсвийг 1,141.1 мянга, Ерөнхий боловсролын байгууллагууд 6,277.7 мянга, Эрүүл мэндийн төв 1,128.5 мянга, Соёлын төв 854.6 мянган төгрөгөөр тогтмол зардлыг тус тус хэмнэж орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг 55,607.6 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлж, хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийг 129,606.5 мянган төгрөгөөр дутуу олгосонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 7,540.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 97,290.9 мянга нийт 104,830.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 98,686.6 мянга, хөрөнгийн зардалд 6,005.0 мянган төгрөг зарцуулж 139.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 15. Нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	ИТХ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	102,530.9	2,300.0	104,830.9
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,240.0	2,300.0	7,540.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	97,290.9	-	97,290.9
НИЙТ ЗАРЛАГА	102,422.7	2,268.9	104,691.6
Бараа, ажил үйлчилгээний зардал	96,417.7	2,268.9	98,686.6
Хөрөнгийн зардал	6,005.0	-	6,005.0
Төсөвт төвлөрүүлсэн	108.1	31.1	139.2

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Аудитын гол асуудал

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Бууцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Бууцагаан сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №16. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо			
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан
ЗДТГ	1	1		1
ИТХ	1	1		1
ОНХС	1	1		1
ХХС	1	1		1
НИЙТ ЗАРЛАГА	4	4		4

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагыг түүвэрт хамруулсан.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 2,065,922.9 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,824,848.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 15. Төсвийн гүйцэтгэлийн тайлан хөтөлбөрөөр

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,817,829.6	1,616,031.1	201,798.5	88.9
70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	88870.2	87729.051	1141.149	98.7
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	88170.2	87029.051	1141.149	98.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	700	700	0	100.0
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	444937.2	437754.68	7182.519	98.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	291742	286483.55	5258.449	98.2
80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	80855.9	80451.779	404.121	99.5
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1000	1000	0	100.0
80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөг	22339.3	22339.3	0	100.0
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	40000	39980.45	19.55	100.0
82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах	9000	7499.6	1500.4	83.3
70503 Орон нутгийн зорилтот ХОруулал	435062	379454.4	55607.6	87.2
80904 Нийгмийн зориулалттай барилга	94813.7	109122.4	-14308.7	115.1
83401 ОНХС - Итгэлцүүрээр олгох	210398.5	203798	6600.5	96.9
83402 ОНХС - Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	6798	0	6798	-
83403 ОНХС - Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	368.6	0	368.6	-
83405 ОНХС - Малын тоо толгойн албан татвар	80063.4	36700	43363.4	45.8
83406 ОНХС - Бусад	42619.8	29834	12785.8	70.0
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	81298.4	80169.904	1128.496	98.6
80112 Нийтлэг үйлчилгээ	81298.4	80169.904	1128.496	
71702 Соёл урлаг	48362.2	47507.574	854.626	98.2
80112 Нийтлэг үйлчилгээ	48362.2	47507.574	854.626	98.2
71801 Сургуулийн өмнөх боловсрол	73334.8	69433.625	3901.175	94.7
80112 Нийтлэг үйлчилгээ	73334.8	69433.625	3901.175	94.7
71802 Ерөнхий боловсрол	410776.8	408400.27	2376.527	99.4
80112 Нийтлэг үйлчилгээ	410776.8	408400.27	2376.527	99.4
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	235188	105581.55	129606.5	44.9
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	235188	105581.55	129606.5	44.9

Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгий тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,082,266.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 31,234.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 21,863.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сумын хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөөнд захиргааны зориулалттай шинээр байшин барилга тусгаагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар ашиглах боломжгүй болохыг тогтоосон тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гарснаас бусад тохиолдолд захиргааны зориулалтаар барилга шинээр барихыг хориглоно” гэсэн заалттай нийцэж байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст орон нутгийн хөгжлийн сангаас олгосон хөрөнгийн санхүүжилттэй холбоотой 466,834.9 мянган төгрөгийн 26 мэдээллийг байршуулаагүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба асуудлын бүртгэлийг танилцуулсан, жилийн эцсээр дүнг нэгтгэн танилцуулсан болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 62,525.8 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 110 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 16. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	6	78,416.6	6	78,416.6	0	0	100
Нийт	6	78,416.6	6	78,416.6	0	0	100

Эх сурвалж: Шийдвэрийн хэрэгжилт

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 27,453.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс зөрчлийг арилгах 3 албан шаардлага өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Албан шаардлага

5.1.1. Тус сумын Засаг даргын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр гаргаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ”, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалттай нийцүүлэн тайлагнаж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.1.2. Малын тоо толгойн албан татварын орлогоор тайлант онд 80,063.4 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн ч 58,040.0 мянган төгрөг төвлөрүүлж 27,453.4 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1. дэх “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд заасан хугацаанд төвлөрүүлээгүй малын тоо, толгойн албан татварын 27,453.4 мянган төгрөгийг орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.1.3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст орон нутгийн хөгжлийн сан болон хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хөрөнгийн санхүүжилтийн зээлтэй холбоотой 466,834.9 мянган төгрөгийн 17 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утгач	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр гаргаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	-			1	-		
Малын тоо толгойн албан татварын орлогоор тайлант онд 80,063.4 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн ч 58,040.0 мянган төгрөг төвлөрүүлж 27,453.4 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн.	1	27,453.4			1	27,453.4		
Дүн	2	27,453.4			2	27,453.4		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утгач	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст орон нутгийн хөгжлийн сан болон хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хөрөнгийн санхүүжилтийн зээлтэй холбоотой 466,834.9 мянган төгрөгийн 17 мэдээллийг байршуулаагүй.	1	0			1	0		
Дүн	1	0			1	0		